

[www.sankhuuginbolovsrol.mn](http://www.sankhuuginbolovsrol.mn)



# ӨРХИЙН ТӨСӨВ

# 1. ӨРХИЙН ТӨСӨВ, ТҮҮНИЙ БҮТЭЦ

**Өрхийн төсөв** - энгийн байдлаар тодорхойлбол, өрхийн мөнгөн орлого, зарлагын төлөвлөгөөг өрхийн төсөв гэнэ.

Өрхийн төсөвийн үндсэн ойлголтууд:

- ✓ Орлого
- ✓ Зарлага
- ✓ Хуримтлал
- ✓ Өр төлбөр

## ОРЛОГО

*Хийж гүйцэтгэсэн ажлынхаа төлөө авсан, эсвэл бүтээгдэхүүн үйлчилгээг худалдан авагчдад зарж борлуулснаас олсон мөнгө*

## ЗАРЛАГА

*Өрхийн гишүүдийн хэрэгцээт бараа, үйлчилгээг худалдан авахад зарцуулж буй мөнгө.*

## ХУРИМТЛАЛ

*Ирээдүйн хэрэгцээнд зориулан хадгалж, хуримтлуулсан мөнгө.*

## ӨР ТӨЛБӨР


*Өрхийн гишүүдийн бусдад төлөх ёстой мөнгө буюу хуулиар хүлээсэн санхүүгийн үүрэг.*

Төсөв нь орлого, зарлага гэсэн үндсэн бүтэцтэй байна.

Гэр бүлийн гишүүдийн нас, хүйс боловсрол, эрхэлж буй ажил, мэргэжил зэргээс хамааран өрхийн орлого харилцан адилгүй байна. Зарим айлын орлого цалин, хөдөлмөрийн хөлсний орлогоос бүрддэг бол, заримынх нь бизнесийн, түрээсийн гэх мэт олон төрлийн орлогын эх үүсвэртэй байна.

# 1. ӨРХИЙН ТӨСӨВ, ТҮҮНИЙ БҮТЭЦ

Өрхийн орлогыг олон шинжээр ангилж болох бөгөөд доорх зурагт үзүүлсэн ангилал нь ХХОАТ-ын зорилгоор ангилсан ангилал юм. Үүнээс гадна жил бүр МУ-ын ҮСХ-ноос өрхийн сарын дундаж орлогын бүтцийг тодорхойлон гаргадаг.



# 1. ӨРХИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ


- ✓ Өрхийн орлого хязгаарлагдмал, хэрэгцээ хязгааргүй байдаг тул гишүүдийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээ, амь зуулгыг хангахын тулд өрхийн орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай болдог.
- ✓ Үүний тулд өрхийн боломж, гишүүдийн тоо, бүтэц, нас, хүйсийн онцлогоос хамаарч орлого нэмэгдүүлэх боломжийг ашиглах хэрэгтэй.



## 2. ӨРХИЙН ТӨСӨВ ЗОХИОХ АРГАЧЛАЛ

Өрхийн төсөв зохиохдоо хамгийн багадаа 3 сарын турш орлого, зарлагаа нэг бүрчлэн бүртгэсэн байх ёстой.

Өрхийн орлого, зарлагаа бүртгэснээр та ашиг, алдагдал болон цэвэр хөрөнгийн дүнгээ тооцож чадна.



# ӨРХИЙН ТӨСӨВ ЗОХИОХ АРГАЧЛАЛ

*Өрхийн төсөв зохиох аргачлал:*



**Компьютерийн системийн арга:**

Өрхийн төсвөө тодорхой түвшинд алхамчлах хэрэгтэй. Жишээ нь: өрхийн орлого, зарлагаа бүртгэх, зарлагын түүхээ дүгнэж, тэвчиж болох зардлаа олж илрүүлэн, өрхийн төсвөө зохиох, өрхийн төсвөө чанд мөрдөн санхүүгийн сахилга баттай байх.

**Дугтуйт төсвийн арга:**

Зардлын төрөл бүрээр дугтуй бэлтгэн өрхийн төсвийн тооцоогоо хуваарлиж, төлөвлөгөөтэй зарцуулах арга юм. Дугтуйт төсвийн аргыг хэрэгжүүлэхийн өмнө орлого, зарлагаа бүртгэх бөгөөд түүнд үндэслэн орлого, зарлагаа төлөвлөнө. Өрхийн орлогыг зарцуулахын өмнө бага ч гэсэн мөнгийг хуримтлалдаа тогтмол хийсний дараа хэрэглээнд хуваарилна.

### 3. ӨРХИЙН ТӨСӨВ ХӨТЛӨЛТИЙН ДАВУУ ТАЛ, АЧ ХОЛБОГДОЛ

#### **Өрхийн төсвөө хөтөлсөнөөр дараах давуу талтай:**

- Гэр бүлд санхүүгийн маргаан гарахгүй.
- Гэр бүл бүх гишүүдийн хэрэгцээг хангах төлөвлөгөөтэй болно.
- Нийгэм эдийн засгийн эрсдэлийг даван туулах арга замаа хайхад тусална.

#### **Өрхийн төсвөө хөтлөхгүй байх нь дараах сөрөг талтай:**

- Хэт үрэлгэн зардал их гаргадаг.
- Төлөвлөгөөгүй зардал гарах үед гэр бүлийн амьдрал хүндрэлд орно.
- Гэр бүлийн зөрчил бий болно.
- Өдөр тутмын тооцоогүй амьдрал нь ирээдүйн эдийн засгийн эмзэг, ядуу байдалд хүргэх нь элбэг.
- Өрхийн төсөв хөтлөхгүй байх нь хадгалах, хуримтлуулах сэтгэлээг бий болгохгүй байх хандлагатай юм.



**Баярлалаа**